**ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Хөвсгөл аймгийн Мөрөн сумын "Мөрөн-Германы хамтын ажиллагаа" төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХӨА-2024/112/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Мөрөн сум

2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг:tegshdelgerb@audit.gov.mn
Аудитор: Г.Ичинхорлоо
Утас:88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn
Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа
Утас:99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com
Аудитор Ц.Мөнхтуяа
Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.09.26 № 01/233

танай ___________-ны № ___________-т

МӨРӨН-ГЕРМАНЫ ХАМТЫН АЖИЛЛАГАА ТӨСЛИЙН УДИРДАГЧ МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГА Х.ТАЙВАНБАЯР ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөрөн-Германы хамтын ажиллагаа төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мөрөн-Германы хамтын ажиллагаа төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Холбооны Бүгд Найрамдах Герман улсын Бранденбург мужийн Барут/Марк хот, Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын хамтын ажиллагааны хүрээнд "Мөрөн хотын ахуйн хог хаягдлын тогтвортой менежмент" төслийн санхүүжилтэд 2023 онд Германы талаас 20,000 евро буюу 74,109.0 мянган төгрөг, Мөрөн сумын Орон нутгийн хөгжлийн сангаас 12,000.0 мянган төгрөг, нийт 86,109.0 мянган төгрөгөөр санхүүжүүлж мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 43,865.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитаар Нягтлан бодох бүртгэл, төслийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой алдаа, зөрчил илрээгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Төслийг хэрэгжүүлснээр Мөрөн хотын ундны ус болон хогны менежментийг сайжруулж, Герман улсын байгальд ээлтэй технологийг цаашид нэвтрүүлэхэд чиглэсэн бааз суурийг бий болгосон байна.

Герман улсын талаас сүүлийн санхүүжилтийн зарцуулалтын хуваарийг баталж 2023 оны 11-р сарын 26-ны өдөр санхүүжилтийг иргүүлсэн боловч хүйтний улирал

0724/0565

эхэлсэнтэй холбоотойгоор төлөвлөгдсөн 41.984.2 мянган төгрөгийн 5 ажил дараа онд хэрэгжихээр хойшлогдсон байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **154,690.45** | **44,020,257.15** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **154,690.45** | **44,020,257.15** |
| **31100** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | | |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **154,690.45** | **44,020,257.15** |
| **31210** | **Төгрөг** | **154,690.45** | **44,020,257.15** |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 154,690.45 | 44,020,257.15 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **154,690.45** | **44,020,257.15** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **7,062,836.00** | |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **7,062,836.00** | |
| **41300** | **Өглөг** | **7,062,836.00** | |
| **41360** | **Бусад өглөг** | **7,062,836.00** | |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 7,062,836.00 | |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **-6,908,145.55** | **44,020,257.15** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **-6,908,145.55** | **44,020,257.15** |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **-6,908,145.55** | **44,020,257.15** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 233,965,026.00 | -6,908,145.55 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -240,873,171.55 | 50,928,402.70 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **154,690.45** | **44,020,257.15** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **200,219,500.00** | **86,109,000.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **200,219,500.00** | **86,109,000.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **200,219,500.00** | **86,109,000.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 200,219,500.00 | 86,109,000.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **441,092,671.55** | **35,180,597.30** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **441,092,671.55** | **35,180,597.30** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **441,092,671.55** | **35,180,597.30** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **441,092,671.55** | **35,180,597.30** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 441,092,671.55 | 35,180,597.30 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **-240,873,171.55** | **50,928,402.70** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **-240,873,171.55** | **50,928,402.70** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **200,219,500.00** | **86,109,000.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **200,219,500.00** | **86,109,000.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 200,219,500.00 | 86,109,000.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **434,029,835.55** | **42,243,433.30** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **434,029,835.55** | **42,243,433.30** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **434,029,835.55** | **42,243,433.30** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **434,029,835.55** | **42,243,433.30** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 434,029,835.55 | 42,243,433.30 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **-233,810,335.55** | **43,865,566.70** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **-233,810,335.55** | **43,865,566.70** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 233,965,026.00 | 154,690.45 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 154,690.45 | 44,020,257.15 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | | | 233,965,026.00 | 233,965,026.00 |
| **3** | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | 233,965,026.00 | 233,965,026.00 |
| **9** | Тайлант үеийн үр дүн | | | -240,873,171.55 | -240,873,171.55 |
| **10** | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | | | -6,908,145.55 | -6,908,145.55 |
| **11** | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | | | -6,908,145.55 | -6,908,145.55 |
| **13** | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | -6,908,145.55 | -6,908,145.55 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | | | 50,928,402.70 | 50,928,402.70 |
| **20** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | | **44,020,257.15** | **44,020,257.15** |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 104,726.2 мянган төгрөгийн зөрчил илэрч, 1 зөвлөмжийг төслийн удирдагч, нягтлан бодогч нарт хүргүүлсэн. Материаллаг зөрчил илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Мөрөн-Германы хамтын ажиллагаа төсөл нь www.shilendans.gov.mn цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 86,109.0 мянган төгрөгийн 4 мэдээлэл, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 18,617.2 мянган төгрөгийн 3 мэдээллийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалтыг хэрэгжүүлээгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь, бүрэн байршуулах. 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 86,109.0 мянган төгрөгийн 4 мэдээлэл, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 18,617.2 мянган төгрөгийн 3 мэдээллийг байршуулаагүй | 1 | 104,726.2 | | | 1 | 104,726.2 |
| **Нийт дүн** | 1 | 104,726.2 | | | 1 | 104,726.2 |
| | 1 | 104,726.2 | | | 1 | 104,726.2 |

## 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | Аудитад хамрагдах | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Төсөл, хөтөлбөр | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |